

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Хүний эрх, хүүхэд, эмэгтэйчүүд, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалдаг ТББ-ын ажилтан, судлаач, мэргэжилтнээс бүрдсэн баг 2014 оны нэгдүгээр сард Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг хэлэлцлээ. Хэлэлцүүлэгт оролцогчид хуулийн төслийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуультай харьцуулж, уг хуулийн төсөл нь хүний эрхийн шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн хангаж байгааг үнэллээ.

Уг хуулийн төсөл нь Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээний заалттай нийцэж байгаа бөгөөд хүчирхийллийн хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлын хамгааллыг сайжруулах, байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох хүрээнд олон чухал зохицуулалт тусгасныг тэмдэглэхийн хамт хэлэлцүүлгийн явцад гарсан санал, шүүмжийг нэгтгэн танилцуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс судлаач Ц.Ариунболд, Х.Билгүүнзаяа, Ж.Даваасүрэн, М.Туяа, Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбооноос өмгөөлөгч М.Жаргалсайхан, Ш.Жаргалсайхан, Х.Номинцэцэг, В.Ганболд, С.Оюун болон бусад ТББ-аас Ц.Батсайхан (НДЭХ-ий Төв аймгийн салбар зөвлөл), Б.Баттогтох (МонАме судалгааны төв), Ш.Гансүрэн (Ирээдүйн босго), А. Долгор (Хөгжлийн хэлхээ), Г.Итгэл (Монголын эрх зүйчдийн холбоо), Ш.Лхагвасүрэн (Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг), Т.Маамуу (Өв тэгш хөгжлийг дэмжих сан), Д.Мөнхнасан (АГБТ төв), Д.Мөнхцэцэг (Ирээдүйн босго), Д.Отгонцэцэг (Хүүхэд өмгөөлөл төв), Ц.Оюунбаатар (Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо), Д.Цэнд-Аюуш (Хууль, хүний эрх төв), Н.Шажинбат (И Эл Си нөхөрлөл), Ч.Энхмандах (Хил хязгааргүй алхам) болон Б. Хишигсайхан (Нээлттэй Нийгэм Форум) нар оролцсон юм.

- Хуулийн төслийн 6.1-д «гэр бүлийн хүчирхийлэл» гэдгийг Гэмт хэргийн тухай болон Зөрчлийн тухай хуульд заасан үйлдэл, эс үйлдэхүйг тус хуулийн 3.1-д заасан этгээд нөгөө этгээдийн эсрэг үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүйг хэлнэ гэсэн боловч эдгээр хуульд үйлдэл, эс үйлдэхүйг тодорхойлоогүй байна. Энэ нь Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 13-р зүйлийн 13.2.2-т заасан «нэр томъёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох» гэсэн шаардлагад нийцэхгүй байна.

Санал: «Гэр бүлийн хүчирхийлэл гэж энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн, сэтгэл санааны дарамтанд оруулсан, эдийн засаг, эд материалын болон биеийн хүчний эрхшээлд байлгасан, хясан боогдуулсан Гэмт хэргийн тухай болон Зөрчлийн тухай хуульд заасан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ» гэж тодорхойлох.

- ☑ Хуулийн төслийн 19.1.1-д зааснаар «төлбөрийн чадваргүй гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, насанд хүрээгүй хүүхдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх» чиг үүргийг Прокурорын байгууллагад хүлээлгэжээ. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Прокурорын байгууллагын үндсэн чиг үүрэг нь «хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох» билээ. Тиймээс хуулийн төслийн дээрх заалт хэрхэн хэрэгжих нь эргэлзээтэй юм.

Санал: Төлбөрийн чадваргүй гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах боломжийг хуулийн төсөлд нарийвчлан тусгаж, хэрэгжихүйц зохицуулалтыг бий болгох.

- ☑ Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд «хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт»-ыг тодорхойлж, сургалтын хөтөлбөр батлах, хэрэгжүүлж зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг зохицуулсан хэдий ч хариуцах байгууллагын үндсэн чиг үүрэгтэй нийцүүлээгүйгээс хууль батлагдаад 10 жил болоход энэ зохицуулалт хэрэгжээгүй. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зан үйлд нөлөөлөх албадан сургалт¹-ыг «Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмаар тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна» хэмээн томъёолжээ. Ингэснээр өмнөх хуулийн хэрэгжээгүй зохицуулалт хэрэгжих бүрэн боломжтой болж буй эсэхийг анхаарах шаардлагатай юм.

Санал: Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэлбэр, агуулга ямар байх, түүнийг хэн хэрэгжүүлэх, хүчирхийлэл үйлдэгчдэд албадан сургалтад хамрагдах төрийн албадлагыг хэрэглэх эрх зүйн үндэслэлийг тодорхой болгох зэргээр үйл ажиллагааны журмыг нарийвчлан тодорхойлж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцооны нэг хэсэг болгон хуульчлах.

- ☑ Хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хамгаалах, үзүүлэх үйлчилгээний талаар нарийвчилсан зохицуулалт оруулсан нь сайшаалтай боловч хүчирхийлэл үйлдэгчдэд хандсан үйл ажиллагааг «Зөрчлийн тухай хууль болон Гэмт хэргийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх», «зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах» зэргээр хязгаарлажээ. Нэг талаас, хүчирхийлэл үйлдэгчдэд хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүй ёсны боловч нөгөө талаас, түүнд үзүүлэх «зөв зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээ»-г өргөжүүлэх нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх зорилготой нийцнэ.

Санал: Хүчирхийлэл үйлдэгчдэд зан үйлээ өөрчлөхөд нөлөөлөх шинэлэг, үр дүнтэй арга хэмжээг хуулийн төсөлд тусгах шаардлагатай. Тухайлбал, гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг байж болох юм.

¹ Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь хүний ухамсар, оюун санаанд нөлөөлөх байдлаар хийсэн үйлдэлдээ харамсах, дахин хүчирхийлэл үйлдэхгүй байх сэтгэл зүйг төлөвшүүлдэг төдийгүй, хүчирхийлэл үйлдсэний дараа хариуцлага хүлээлгэхээс илүү эерэг үр дагавартай билээ. Эрх зүйн үр дагавар бий болгож буй зохицуулалтыг хэрэгжүүлэх процесс ажиллагааг хуульд тодорхой заахгүй орхих нь зохицуулалт зорилгодоо хүрэхгүй, тунхаглалын шинжтэй заалт болоход хүрдэг.

- ☑ Хуулийн төслийн 15.2-т «мэргэшсэн төрийн бус байгууллага»-ыг ямар шаардлага, шалгуураар хэн тогтоох нь тодорхойгүй байна. Мөн 15.1, 15.4, 15.5, 27.3-т заасан «гэрээлэн гүйцэтгэх», «гэрээлэх» гэсэн нэр томъёо нь Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэдэг нэр томъёотой зөрчилдөж байна. Үүний зэрэгцээ хуулийн төслийн 21-р зүйлийн 21.1.3, 21.1.7-д «багаар үйлчилгээ үзүүлэх» талаар заасан хэдий ч үүнд ямар үйлчилгээ багтах, хэн үзүүлэх зэрэг нь тодорхойгүй байна. Энэ мэт хууль боловсруулах техник шаардлагад нийцүүлэх зарим зүйл, заалт байна.

Санал: Төслийн 15.3-т заасан магадлан итгэмжлэх сонгон шалгаруулалтад тэнцсэн төрийн бус байгууллагыг «мэргэшсэн» гэж үзэх эсэхийг тодорхой зааж өгөх шаардлагатай. «Гэрээлэн гүйцэтгэх», «гэрээлэх» гэсэн нэр томъёог «гэрээний үндсэн дээр гүйцэтгэх» хэмээн өөрчлөх нь зохимжтой. Хуулийн төслийн 33 дугаар зүйлд заасан «Сэтгэл зүйн үйлчилгээ»-г 28 дугаар зүйлд заасан хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөлд оруулж тусгах замаар хуулийн техникийн алдааг засах нь зүйтэй. Мөн хуулийн төслийн 21-р зүйлийн 21.1.3, 21.1.7-д «багаар үйлчилгээ үзүүлэх» гэдгийг нарийвчлан тодруулах.

- ☑ Хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хамгаалах, үзүүлэх үйлчилгээний талаар нарийвчилсан зохицуулалт оруулсан нь сайшаалтай боловч хүчирхийлэл үйлдэгчдэд хандсан үйл ажиллагааг «Зөрчлийн тухай хууль болон Гэмт хэргийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх», «зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах» зэргээр хязгаарлажээ. Нэг талаас, хүчирхийлэл үйлдэгчдэд хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүй ёсны боловч нөгөө талаас, түүнд үзүүлэх «зөв зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээ»-г өргөжүүлэх нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх зорилготой нийцнэ.

Санал: Хүчирхийлэл үйлдэгчдэд зан үйлээ өөрчлөхөд нөлөөлөх шинэлэг, үр дүнтэй арга хэмжээг хуулийн төсөлд тусгах шаардлагатай. Тухайлбал, гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг байж болох юм.

- ☑ Хуулийн төсөлд Салбар зөвлөл нь яамд болон аймаг, нийслэлийн салбар Зөвлөлийн тайланг жилд нэг удаа хүлээн авч Засгийн газарт тайлагнахаар байгаа нь ажлын үр дүнг хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг хурдан, шуурхай төлөвлөх шаардлагыг хангахгүй байна. Үүний зэрэгцээ үйл ажиллагааны тайланг иргэдэд нээлттэй, ил тод байлгах талаар тодорхой зохицуулалтыг тусгах нь зүйтэй.

Санал: Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайланг Салбар зөвлөл нь хагас жил тутамд хэлэлцдэг байх, үйл ажиллагааны тайланг иргэдэд нээлттэй ил тод болгох талаар холбогдох заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай. Мөн тус хуулийн төслийн 9-р зүйлийн 9.2-т «... гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр» гэсний дараа «хүчирхийлэлд өртсөн тодорхой эмзэг бүлгийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг» гэж нэмэх нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх салбар зөвлөлийн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой.

- ☑ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зүйл, заалтыг зөрчих, хуулиар хүлээх үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог төсөлд сул зохицуулжээ. Энэ нь Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 12-р зүйлийн 12.1.8-д заасан «... эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тодорхой заасан байх» гэсэн шаардлагад нийцэхгүй байна. Хуулийн төслийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2-т «энэ хуульд заасныг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ», «энэ хуулиар үүрэг хүлээсэн албан тушаалтан үүргээ зөрчсөн нь ял шийтгэл хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулна» гэжээ. Гэтэл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн, уг хуульд заасан үүргээ биелүүлээгүй эрх бүхий этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх талаар Зөрчлийн тухай хуулийн төсөлд огт туссаагүй байна.

Санал: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн, уг хуульд заасан үүргээ биелүүлээгүй эрх бүхий этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог Зөрчлийн тухай хуульд тодорхой тусгах нь зүйтэй.

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**
ННФ-ын Засаглалын
хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn